

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФЫН ҮНДЭСЛЭЛИЙГ ХЯНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Харилцаа холбооны салбарын давамгайллагч үйлчлэгч болон шинээр үйлчилгээ эрхлэхээр хүсэлт гаргасан хуулийн этгээдийн үйлчилгээний тариф тогтоосон үндэслэлийг хянах, тус салбарт давамгайллагч үйлчилгээ эрхлэгчдээс үйлчилгээний тарифтаа өөрчлөлт оруулах болон шинэчлэн тогтоосон тарифын үндэслэлийг хянах, үйлчилгээний тарифын талаар ирүүлсэн санал хүсэлт маргаантай асуудлыг шийдвэрлэхээр тухайн үйлчлэгчийн үйлчилгээний тарифын үндэслэлийг хянахад энэхүү журмыг мөрдлөгө болгоно.
- 1.2 Харилцаа холбооны зах зээл дээрхи үйлчлэгч нар нь өөрийн үйлчилгээний тарифыг ХХЗХ-ны 2003 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлал”-ын дагуу тогтооно.

Хоёр. Тарифын үндэслэлийг хянах

2.1 Давамгайллагч үйлчилгээ эрхлэгчид болон шинээр үйлчилгээ эрхлэгч нар нь үйлчилгээний тариф тогтоосон үндэслэлийг хянуулахаар үйлчилгээ эхлэхээс өмнө 45-аас доошгүй хоногийн өмнө дараахи материалыг үнийн саналын хамт зохицуулах хороонд ирүүлнэ. Үүнд:

1. Аудитын байгууллагаар батлагдсан санхүүгийн тайлан, шинээр үйлчилгээ эрхлэх бол эхлэлтийн баланс
2. Үйлчилгээ тус бүрээр тооцсон өртгийн тайлан, тооцоо
3. Тарифын саналтай холбогдсон бусад тооцоо, судалгаанууд

2.2 Зохицуулах хороо нь үйлчилгээний тарифын үндэслэлийг хянуулахаар ирүүлсэн материал болон маргаантай асуудлыг шийдвэрлэхээр тухайн үйлчлэгчээс гаргуулан авсан материалуудыг хүлээн авч танилцаад нэмэлт мэдээлэл, тооцоо судалгаа шаардлагатай бол тухайн үйлчлэгчээс шаардаж гаргуулан авна. Тухайн үйлчлэгчийн тарифын үндэслэлийг хянуулахаар ирүүлсэн материал нь хангалттай гэж үзвэл ажлын 14-21 хоногийн дотор тухайн байгууллагын санхүүгийн байдалд үнэлэлт дүгнэлт гаргаж тариф тогтоох аргачлалуудаар тооцоололтыг хийж тарифт шингээсэн ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь хэмжээ нь зах зээлийн өрсөлдөөний байдал, инфляцын түвшинтэй хир зэрэг уялдаж байгааг судлан үнэлэлт дүгнэлт гаргана.

2.3 Давамгайллагч үйлчилгээний тарифын үндэслэлийг хянаж гаргасан санал дүгнэлт болон шаардлагатай гэж үзвэл маргаантай асуудлуудтай холбогдсон тарифын үндэслэлийг хянаж гаргасан санал дүгнэлтийг холбогдох албанаас хорооны хуралдаанд оруулж хэлэлцүүлэн, хорооны хуралдаанаас гарсан шийдвэрийг үйлчилгээ эрхлэгч нарт хүргүүлнэ.

Гурав.Тарифыг хянахад баримтлах үндсэн зарчимууд

Давамгайлагч үйлчлэгч нь ижил төрлийн үйлчилгээ эрхлэгчдийг зах зээлээс шахах зорилгоор хэт бага тариф тогтоосон эсэхийг хянах

Шинээр эрхлэх үйлчилгээний хувьд тухайн үйлчилгээний тарифыг ижил төрлийн үйлчилгээ эрхлэгчийн тарифтай харьцуулах, ялгавартай тариф тогтоогдсон эсэхийг хянах

Давамгайлагч үйлчлэгчээр бүх нийтийн үйлчилгээний үүргийг хангуулах, зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх үүднээс тарифт шингээсэн ашгийн хувь хэмжээг тогтоох

Мөрдөгдөж байгаа тарифыг нэмэгдүүлэх хувь хэмжээ нь инфляцын түвшинтэй хэрхэн уялдаж байгааг хянах

Өрсөлдөөнт зах зээл дэх зарим үйлчилгээний үнэ тарифыг үйлчилгээний хүрээг өргөтгөх, үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэх үүднээс өртгөөсөө доогуур үнээр тогтоогдсон эсэхийг хянах

Давамгайлагч үйлчлэгч болон шинээр үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээний тариф нь өртөг зардалтайгаа хэрхэн уялдаж байгаа болон тарифын тэнцвэржилт ямар түвшинд байгааг хянах

Дөрөв.Тарифыг хянахад хэрэглэгдэх аргачлалууд

4.1 Зах зээл дээр ижил төрлийн үйлчилгээ эрхлэгчдийн тариф болон бусад улс орнуудын тухайн үйлчилгээний тарифуудтай жиших байдлаар тарифыг тогтоосон бол үнийн харьцуулалт хийх аргаар / benchmarking / тарифыг хянана.

4.2 Давамгайлагч үйлчилгээний тарифыг тодорхой хугацаанд тогтвортой байлгах, эсхүл зохицуулах байгууллагаас тухайн үйлчилгээний тарифын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, үйлчилгээний тарифыг аажмаар өртөгт нь хүртэл тэнцвэржүүлэх зорилт тавьж байгаа тохиолдлуудад тарифын дээд болон доод хязгаарыг тогтоож болох бөгөөд энэ үед үнийн хязгаар тогтоох аргачлалаар / price cap / тарифыг тогтоосон үндэслэлийг хянана.

4.3 Давамгайлагч үйлчилгээ болон шинээр эрхлэх үйлчилгээний өртөг болон хөрөнгө оруулалтын хэмжээг үндэслэн тарифыг тогтоосон бол уг тарифын үндэслэлийг хянахдаа өртөг, хөрөнгө оруулалтын өгөөжид үндэслэх аргыг / cost based / ашиглана.

Тав. Үйлчилгээний тарифын мөрдөлтөнд хяналт тавих

5.1 Зохицуулах хорооноос үндэслэлийг нь хянаж тогтоосон үйлчилгээний тарифыг хэрэгжиж эхлэхээс 15-30 хоногийн өмнө нийтэд сурталчилах ажлыг үйлчилгээ эрхлэгч нар зохион байгуулах бөгөөд хэрэгжилтэнд холбогдох албанаас хяналт тавина.

5.2 Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилт болон төлөвлөгөөт хяналт шалгалт хийх үедээ тухайн үйлчлэгчийн үйлчилгээний тарифын

мөрдөлтөнд шалгалт хийж, шаардлагатай гэж үзвэл тариф тогтоосон үндэслэлийг үйлчилгээний тариф хянах аргачлалын дагуу тариф тогтоосон үндэслэлийг хянаж холбогдох шийдвэрийг гаргана.

- 5.3 Зохицуулах хорооноос үйлчилгээний тарифын талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын явцад шалгаж шийдвэрийг хэрэгжүүлээгүй үйлчлэгчид Харилцаа холбооны тухай хуулийн 15.1.1 заалтын дагуу холбогдох арга хэмжээг авна.

----- о О о -----